

ХАШААТ СУМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛУУДЫН БҮРТГЭН БАРИМТЖУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ БОЛОН ХАЙГУУЛ СУДАЛГАА

Дэлхийн Өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын хамгаалалтын захиргаа, Архангай аймгийн Хашаат сумын Соёлын төвтэй хамтран 2019 оны 10-р сарын 05-ноос 10-р сарын 08-ны хооронд Хашаат сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын мониторинг тандан болон археологийн хайгуул судалгаа явуулж, Монгол улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн маягтын дагуу бүртгэн баримтжуулалтыг сайжруулахад арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаа.




Зураг 1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулалт, хайгуул судалгааны ажлын явц.



Зураг 2. Шинээр илрүүлсэн булш, хиргисүүрийн цогцолбор дурсгал (энгэрийн өвөлжөө).

Хашаат сумын үл хөдлөх дурсгалуудын бүртгэл мэдээллийн сангийн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан, 285 гэрэл зураг, 40 гаруй минутын дүрс бичлэгээр баяжуулж, хамрах хүрээ, нягтаршилыг тодорхойлж газарзүйн байршлыг харуулсан зураглал боловсруулан ИТХ, Соёлын төвд хүлээлгэн өгөв.



Зураг 3. Хашаат сумын түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын нисдэг камераар хийсэн дүрс бичлэг.



Зураг 4. Судалгааны ажлын тайлан болон бусад материалуудыг хүлээлгэн өгч буй байдал.